



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/765

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 а, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, бусад зайлшгүй арга хэмжээнүүдийг санхүүжүүлэх зорилгоор дараах арга хэмжээнүүдийг санхүүжүүлсүгэй.

- Монгол Улсын Хөдөлмөрийн баатар Н.Жанцанноровт хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ, "МОРИН ХУУР"-ын чуулгын зардалд 6000.0 мянган төгрөг,

- Арвайхээр сумын багийн спорт заалны халаалтын зардлын дутуу санхүүжилтийг олгоход 1945.0 мянган төгрөг,

- Арвайхээр сумын Найрамдал СӨХ-д дэмжлэг үзүүлэх 7280.0 мянган төгрөг,

-10 аймгийн Сэтгүүлчдийн урлаг, спортын наадам, бүсийн сургалтын зардалд 11585.0 мянган төгрөг,

- Монголын Хараагүйчүүдийн холбооны Өвөрхангай аймаг дахь салбарт дэмжлэг үзүүлэхэд 2500.0 мянган төгрөг,

- Ус, цаг уур орчны шинжилгээний албаны цаг уурт зориудаар нөлөөлөх арга хэмжээний зардалд 5000.0 мянган төгрөг,

- Баруунбаян-Улаан суманд ангийн орлогын дутууг нөхөн олгох 8000.0 мянган төгрөг,

- Нарийнтээл суманд ангийн орлогын дутууг нөхөн олгох 10000.0 мянган төгрөг буюу нийт 52310.0 (Тавин хоёр сая гурван зуун арван мянга) төгрөг.

2. Дээрх арга хэмжээний 52310.0 (Тавин хоёр сая гурван зуун арван мянга) төгрөгийг аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101443